



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,  
ДҮГНЭЛТ**

**2025 ОН**

## **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН**

2025 оныг Эрүүл мэндийн яамнаас Нийгмийн эрүүл мэндийг тусламж үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбогдуулан “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарласан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгааг хийх, иргэдийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулсан байдалд ЭМГ-ын даргаас батлагдсан удирдамжын дагуу ХШҮ-г 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд үнэлгээ дүгнэлт, зөвлөмж хүргүүлж ажилласан.

### **Нэг. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэл:**

2025 оны жилийн эцсийн байдлаар:

1. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2022.10.31-ний өдрийн А/780 дугаар тушаал) ний хэрэгжилт 97.3%
2. Цартахлын дараах эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.04.18-ний өдрийн А/180 дугаар тушаал)-ний хэрэгжилт 96.4%
3. Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2022.12.05-ний өдрийн А/577 дугаар тушаал)-ний хэрэгжилт 91%
4. Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.03.29-ний өдрийн А/137 дугаар тушаал)-ний хэрэгжилт 94%
5. Эрүүл шүд арга хэмжээ төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024.01.19-ний өдрийн А/27, А/25 дугаар тушаал)-ний хэрэгжилт 91%
6. Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.03.29-ний өдрийн А/148 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90%
7. Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухаан, Биеийн тамир спорт, Хөдөлмөр нийгмийн хамгаалал сайдын 2024.02.20-ний өдрийн А/75, А/09, А/73, А/34 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90%
8. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Ерөнхий сайдын 2024.05.14-ний өдрийн 71 дугаар захирамж)-ний хэрэгжилт 99.2%
9. Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2025.02.06-ний өдрийн А/53, А/37 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90%
10. Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2025.05.30-ний өдрийн А/219 дугаар тушаал)-ний хэрэгжилт 87.4%
11. Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2025.06.12-ний өдрийн А/241 дугаар тушаал)-ний хэрэгжилт 88.3%

2025-2028 онд хэрэгжүүлэх “Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө” МУ-

ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2025.02.06-ний өдрийн А/53, А/37 шинээр батлагдан ирсэн. **Нийт 11 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 93%** байна.

Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн хурлын **10** удаа хуралдаж **26** асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

ЭМГ-ХШҮМХэлтсээс энхний 6 сарын байдлаарх үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А346 тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 6 сараас хойш МУЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ үнэлгээг салбарын хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлгээний зарчмыг баримтлан удирдан зохион байгуулж ажилласан.

**Хоёр. 2025 оны эрүүл мэндийн байгууллагуудын 1,2,3,4 дүгээр улирлын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл**

| ХШҮ<br>Улирал                  | Амин-<br>холбоо<br>ӨЭМТ | Гэрэл<br>тэй<br>ӨЭМТ | Госхот<br>ӨЭМТ | Медстоб<br>ӨЭМТ | Түвшинх<br>олбоо<br>ӨЭМТ | Орхон<br>СЭМТ | Хонгор<br>СЭМТ | Шарын<br>гол<br>СЭМТ | Нэгдсэн<br>эмнэлэг |
|--------------------------------|-------------------------|----------------------|----------------|-----------------|--------------------------|---------------|----------------|----------------------|--------------------|
| 1-р<br>улирал<br>ЭМГД-<br>Б/22 | 92.5                    | 87                   | 97             | 83.5            | 83                       | 70            | 81             | 81.5                 | 88.5               |
| 2-р<br>улирал<br>ЭМГД-<br>Б/49 | 91.2                    | 90                   | 94.3           | 77.7            | 87.5                     | 84.5          | 82             | 88                   | 92                 |
| 3-р<br>улирал<br>ЭМГД-<br>Б/74 | 93                      | 92                   | 90.5           | 87              | 83                       | 85            | 83             | 82                   | 85                 |
| 4-р<br>улирал<br>ЭМГД-<br>Б/88 | 95.7%                   | 91.9                 | 94.3           | 87.5            | 90.9                     | 88.2          | 88.9           | 90.2                 | 95                 |
| Дундаж<br>хувь                 | <b>93.1%</b>            | <b>90.2%</b>         | <b>94%</b>     | <b>83.9%</b>    | <b>86.1%</b>             | <b>83.9%</b>  | <b>88.9%</b>   | <b>85.4%</b>         | <b>90.1%</b>       |
| Ерөнхий<br>Үнэлгээ             | А                       | А                    | А              | В               | В                        | В             | В              | В                    | А                  |

ХШҮ-ний 1,2,3,4 дүгээр улирлын дундаж хувь: **88.4%**  
/өмнөх оноос **3.8** хувиар **өссөн** үзүүлэлттэй байна./

ӨЭМТ-ийн дундаж : 89.5%, /Аминхолбоо-93.1% , Гэрэлтэй-90.2%, Госхот – 94% , Мэдстоб-83.9%, Түвшинхолбоо-86.1% /

СЭМТ-ийн дундаж : 86%, /Шарын гол сум-85.4% , Хонгор сум-88.9 % , Орхон сум-83.9%

Нэгдсэн эмнэлэг: 90.1 %,

**Гурав. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгтгэл**

| Хэрэгжилт          |                                                    | Бүгд   | Зорилтууд                                |                             |                                                 |                          |                         |                           |                      |                                             |
|--------------------|----------------------------------------------------|--------|------------------------------------------|-----------------------------|-------------------------------------------------|--------------------------|-------------------------|---------------------------|----------------------|---------------------------------------------|
|                    |                                                    |        | нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Хүний нөөцийн чадавхижуулах, нийгмийн баталгааг | Эрүүл мэндийн санхүүжилт | Эрүүл мэндийн технологи | Эм зүйн тусламж үйлчилгээ | Мэдээллийн технологи | Удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал |
| Зорилтын тоо       |                                                    | 23     | 5                                        | 7                           | 2                                               | 1                        | 1                       | 1                         | 3                    | 3                                           |
| Арга хэмжээний тоо |                                                    | 105    | 23                                       | 37                          | 11                                              | 4                        | 1                       | 6                         | 9                    | 14                                          |
| Үүнээс             | 85 буюу түүнээс дээш хувьтай<br>“Бүрэн хангалттай” | 99     | 21                                       | 35                          | 11                                              | 3                        | 1                       | 6                         | 8                    | 14                                          |
|                    | 70-85 хүртэл хувь<br>“Хангалттай”                  | 5      | 2                                        | 1                           |                                                 | 1                        |                         |                           | 1                    |                                             |
|                    | 70 хүртэл хувь<br>“Хангалтгүй”                     | 1      |                                          | 1                           |                                                 |                          |                         |                           |                      |                                             |
|                    | Хэрэгжилтийн хувь                                  | 96.94% | 96.5                                     | 96.4                        | 99                                              | 88.75                    | 100                     | 100                       | 96.9                 | 98                                          |
|                    | Хэрэгжилтийн оноо                                  | 4.85   | 4.83                                     | 4.82                        | 4.95                                            | 4.44                     | 5.0                     | 5.0                       | 4.85                 | 4.9                                         |

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл, 23 зорилт, 105 арга хэмжээний хэрэгжилт 96.94 %-тай байна.

Боловсруулсан:

ХШҮМХ-ийн дарга

Б.Золбаясах

Танилцсан:

Газрын дарга

Б.Эрдэнэтулга

